

МОНГОЛ УНГАРЫН ХАРИЛЦАА-55 ЖИЛ

*Л.Пүрэвхүү**

Улс төрийн харилцаа¹

Дипломат харилцаа

Монгол Улс, Унгар улс хоёр 1950 оны 4 дүгээр сарын 28-нд дипломат харилцаа тогтоосон ба 1965 оны 8 дугаар сарын 3-наас Элчин сайдын түвшинд харилцах болсон байна.

Улс хоорондын харилцаа

Унгар улс Евро-атлантын интеграцид нэгдсэнийхээ дараа Ази тивийн улсуудтай түүний дотор Монгол Улстай харилцаа холбоогоо хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа ба Унгар улс Монгол Улсын нэгэн адил 1990 онд нийгмийн шилжилтийн замаар замнаж байгаа орон юм.

Монгол Улс, Унгар улс хоёр нь түүхэн язгуур үндэстэй, уламжлалт найрсаг, харилцан итгэлцэл дээр үндэслэсэн харилцаагаа дээдэлсээр ирсэн юм.

Монгол Улс нь нийгмийн шилжилтийн үед ардчилагдах, зах зээлийн эдийн засагт шилжих явцдаа Унгар улсыг үлгэр жишээ гэж үзэн энэ чиглэлийн туршлагаа солилцох хүсэл эрмэлзэлээр дүүрэн байдаг ба Унгарын олон хууль, эрхийн актуудыг монгол хэл рүү орчуулан өөрсдийн шинэчлэлдээ ашиглаж байгаа билээ.

Монгол Улс нь Унгар улсын олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан учраас 2004 оноос Унгар улс хандивлагч орны хувьд нилээд хэмжээний тусламж дэмжлэг үзүүлж байгаа юм.

Өндөр хэмжээний айлчлалууд, гэрээнд тулгуурласан харилцаанууд:

Монгол Улс, Унгар улс хоорондын хамтын ажиллагааг харилцан хийсэн өндөр хэмжээний айлчлалууд бэхжүүлж хөгжүүлсэн юм. Тухайлбал Унгар улсын Ерөнхийлөгч Гөөнц Арпад 1994 онд Монгол Улсад айлчилсны хариуд Монгол Улсын Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат 1995 онд Унгар улсад айлчилсан билээ.

Тус хоёр улсын Ерөнхийлөгч нарын харилцан хийсэн айлчлалын үр дүнд хоёрулсын дотоод, гадаад шинэ нөхцөл байдалд нийцсэн хамтын ажиллагааны эрх зүйн үндэс тавигдаж, гэрээнд тулгуурласан холбоо харилцааны шинэ тогтолцоо бүрэлдэн бий болсон юм.

Монгол Улс, Унгар улсын Засгийн газрын хооронд Хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих, давхар татвар ноогдуулахгүй байх тухай, Ургамал хамгааллын тухай, Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай гэх мэт гэрээнүүд байгуулагдаж гарын үсэг зурагдсан билээ.

¹Л.Пүрэвхүү - Гамшгаас хамгаалах ерөнхий газрын ажилтан

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхсайхан 1998 оны 1 дүгээр сард Унгар улсад айлчлан тус хоёр улсын хооронд найрамдал хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулж гарын үсэг зурсан нь хоёр улсын хооронд байгуулсан 1984 оны найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээний шинэ нөхцөл байдалд нийцүүлсэн хувилбар байсан юм.

Монгол Улс хуучин Төв болон Зүүн Европын орнуудтай тогтоосон уламжлалт харилцаатай орнуудаас хамгийн түрүүнд Унгар улстай ийм үндсэн гэрээ байгуулах явдлыг эхэлж санаачилсан юм. Унгар улсын хувьд энэ гэрээнд гарын үсэг зуран Монголын ардчилсан шинэчлэлт, өөрчлөлтөнд улс төрийн дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй байсан юм. Энэ гэрээг Монгол Улсын Улсын Их Хурал 1998 оны 7 дугаар сард, Унгар улсын Улсын Хурал 1998 оны 12 дугаар сард батламжилсан юм.

Тус хоёр улсын хууль тогтоох байгууллага хоорондын харилцаа тогтмолжиж байгаа ба үүний хүрээнд дараах айлчлалууд хийгдсэн юм.

Унгар улсаас 1997 онд Улсын Хурлын дэд дарга Короди Мариа, 2001 онд Улсын Хурлын дэд дарга, доктор Сили Каталин нар, Монгол Улсаас 1991, 1996, 1999 онуудад УИХ-ын дарга Р.Гончигдорж, УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж 2003 онд тус тус айлчилсан байна.

Мөн хоёр улсын Гадаад хэргийн яамд хооронд зөвлөлдөх яриа хэлэлцээнүүд явагдаж байдаг юм. Тухайлбал Унгар улсын Гадаад хэргийн яамны Монгол улс хамрагддаг нутаг дэвсгэрийг хариуцдаг төрийн нарийн бичгийн даргын орлогч Улаанбаатарт айлчлан хоёр талын харилцаа болон олон улсын асуудлуудаар яриа хэлэлцээ хийсэн юм. Монгол Улсын Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга 1998 оны 11 дүгээр сард Унгар улсад айлчлан Эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын Монголын хэсгийн даргын хувьд хоёр улсын Эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын Будапештэд зохион байгуулсан хуралд оролцсон юм. Унгар улсын талаас 2001 оны 4 дүгээр сарын 24-27-ны хооронд тус улсын Гадаад хэргийн яамны Нутаг дэвсгэрийн (улс төрийн) газрын болон Консулын газрын дарга нар Монгол Улсад айлчлан Улаанбаатар хотод мэргэжлийн зөвлөлдөөн хийсэн юм. Мөн Гадаад хэргийн төрийн нарийн бичгийн дарга Р.Алтангэрэл 2003 оны 7 дугаар сард Унгар улсад айлчлан Унгар улсын Гадаад хэргийн улс төрийн төрийн нарийн бичгийн дарга Баршоны Андраш, орлогч төрийн нарийн бичгийн дарга Сентиваны Габор нартай Будапештэд уулзсан юм.

Хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр 2003 оны 6 дугаар сарын 18-20-ны хооронд Унгар улсад айлчилж яриа хэлэлцээ хийжээ.

Мөн тус хоёр улсын Цагдаагийн байгууллагууд хооронд хамтын ажиллагаа үүсч хөгжиж байгаа билээ. Монгол Улсын Цагдаагийн

байгууллага Унгар улсын Цагдаагийн байгууллагын дэмжлэгээр Олон улсын Цагдаагийн холбооны хавсарсан гишүүнээр элссэн юм. Энэ хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга 1998 оны 4 дүгээр сард Унгар улсад айлчилсан юм.

Хоёр улсын Гаалийн байгууллагууд хооронд 1996 онд байгуулсан гэрээний үндсэн дээр Монгол Улсын гаалийн мэргэжилтэнгүүдийг Унгар улсад сургах боломж нээгдсэн байна.

Унгар улсын Гааль санхүүгийн хяналтын ерөнхий газрын дарга 1997 онд Монгол Улсад айлчилсан ба Монгол Улсын талаас 2002 онд Гал түймэртэй тэмцэх газрын дарга, 2003 онд Хил хамгаалах ерөнхий газрын дарга, 2004 онд Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга нар Унгар улсад тус тус айлчилсан ба 2005 оны 3 дугаар сард Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга Монгол Улсад айлчлах гэж байна.

Монгол Улс, Унгар улс хоорондын гамшигтай тэмцэх салбар дахь хамтын ажиллагаа

Энэ хамтын ажиллагааны эхлэл 2001 онд тавигдсан ба тэр үед Унгар улсаас Монгол Улсад сууж байсан Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд эрхэмсэг ноён Балог Иштван, хуучнаар Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Д.Хишигбаатар нарын хооронд явагдсан яриа хэлэлцээнүүдийн үр дүнд 2002 оны 3 сарын дундуур Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал ноён Баконди Дөөрдийн урилгаар Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Д.Хишигбаатар, тус газрын ажилтан Л.Пүрэвхүү нар Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газарт 2 хоногийн ажлын айлчлал хийсэн юм.

Энэ айлчлалаар Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал ноён Баконди Дөөрд өөрийн байгууллагын байгуулагдсан түүх, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, тус улсын гамшгийн нөхцөл байдлын талаар төлөөлөгчдөд мэдээлэл хийж, байгууллагынхаа өдөр тутмын үйл ажиллагааг үзүүлж танилцуулсан юм.

Ингээд ноён Баконди Дөөрд, хурандаа Хишигбаатар нарын хооронд яриа хэлэлцээ явагдаж, Монголын Гал түймэртэй тэмцэх газрын 3 шинжээч байцаагч нарын мэргэжлийг дээшлүүлэхээр тохиролцов.

Дээрхи арга хэмжээнүүдэд Унгар улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны зөвлөх Д.Жамбажанцан, I нарийн бичгийн дарга Д.Батжав нар оролцон тус хоёр байгууллага хоорондын хамтын ажиллагааны эхлэлийг тавихад зохих ёсны тус дэмжлэгийг үзүүлсэн юм.

Энэ тохиролцооны дагуу 2002 оны 9-11-р сард тус газрын хоёр шинжээч, нэг ахлах байцаагч, орчуулагч-зохицуулагч Л.Пүрэвхүүгийн хамт тус бүр нэг сарын хугацаагаар тус тусын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн юм.

Энэ сургалтыг дуусах үед Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дэд дарга, одоо тус ерөнхий газрын дарга болсон хошууч генерал ноён Татар Аттила Унгар улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны I нарийн бичгийн дарга Д.Батжав бид нарыг хүлээн авч уулзан хойшид тус хоёр байгууллага хоорондын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн юм.

Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Д.Хишигбаатар 2003 онд Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал ноён Татар Аттилаг хариу айлчлал хийхийг урьсан юм. Энэ айлчлал ажил төрлийн шалтгаанаас болж хойшлогдсоор 2004 онтой золгосон ба 2004 оны эхээр Гал түймэртэй тэмцэх газар, Улсын Иргэний хамгаалалтын газар, Улсын Нөөцийн газрыг нэгтгэж Засгийн газрын тохируулагч агентлаг Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулсан юм. Энэ үед цол ахиж хошууч генерал болсон ноён Татар Аттилаг Монголд айлчлахыг урьсан. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал П.Дашийн урлигыг хүлээн авч 2004 оны 8 дугаар сарын дундуур айлчлахаар бүх бэлтгэлийг хангаж бэлэн болсон байсан боловч яг энэ үед Унгарын Хернад гол үерлэж энэ айлчлал хойшилсон юм.

Саяхан 2005 оны 1 дүгээр сарын дундуур Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал П.Даш, Унгар улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Иллеш Михайг төрийн ордонд хүлээн авч уулзан энэ айлчлалын талаар ярилцсан байна. Ноён Элчин сайд Иллеш Михай айлчлал энэ оны 3 дугаар сард хийгдэх төлөвтэй байгаа талаар мэдээлж хошууч генерал ноён Татар Аттила Монгол Улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газарт лабораторын тоног төхөөрөмжийн тусламж үзүүлэхэд бэлэн байгаа талаар ярьсан ба хошууч генерал П.Даш гамшгийн чиглэлийн ном сурах бичгүүд хүссэн байна.

Монгол Улс Будапешт дэх Элчин сайдын яамаа энэ хавийн бүс нутгийн улс орнуудтай тогтоосон харилцаагаа зохицуулах бүс нутгийн төв байдлаар ажиллуулдаг юм.

Худалдаа, эдийн засгийн харилцаа:

Энэ салбар дахь тус хоёр улсын хамтын ажиллагаа шилжилтийн дараагийн жилүүдэд саарсан юм. Хоёр улсын худалдааны хэмжээ төдий л их биш бөгөөд Унгар улсын Статистикийн төв газрын мэдээгээр бол энэ үзүүлэлт 1999 онд 1,6 ам.доллар, 2000 онд 2,15 ам.доллар, 2001 онд 1,6 ам.доллар, 2002 онд 1,8 ам.доллар, 2003 онд 3,83 ам.доллар болсон байна. Тус хоёр улсын худалдаа бүрэн хэмжээгээр дан ганц Унгар улсын экспортын бүтээгдэхүүнээр хийгдэж байгаа юм. Монгол Улс Унгар улсаас голлон хүнсний бүтээгдэхүүн, эм, (хүн малын эмчилгээний) гутал болон жижиг

үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийг худалдан авдаг юм.

Хоёр тал тус хоёр улсын худалдаа, эдийн засагийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, энэ салбарт шинэ хэлбэрийг эрэлхийлэх сонирхолтой байгаа юм. Үүнд дахин шинээр байгуулагдан ажиллах болсон Эдийн засаг, Худалдаа, Техник-шинжлэх ухааны Хамтын ажиллагааны Комисс дэмжлэг үзүүлэх байх гэдэгт найдаж байна.

Бусад холбоо харилцаа:

Тус хоёр улсад соёл боловсролын салбарт хамтран ажиллах уламжлал тогтсон ба үүний тодорхой нөхцлийг 1996 онд байгуулсан Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээний үндсэн дээр гарын үсэг зурсан 3-4 жилийн хугацаатай ажлын төлөвлөгөөнүүд зохицуулдаг юм. Унгарын Их сургуулийн оюутнуудыг хэлний сургалтанд хамруулахаар Монголд тогтмол явуулж байгаа бөгөөд Унгарын Их сургуулиудад жил бүр бүх зардлыг нь Унгарын тал бүрэн хариуцан 5 оюутныг суралцуулдагийн дээр 5 оюутныг сургалт нь үнэгүй, харин байр, оюутны тэтгэлэг гэх мэтийг нь Монголын тал даах байдлаар бас сургаж байна.

Одоогийн байдлаар ойролцоогоор Монголын 300 оюутан Унгар улсад дээд боловсрол эзэмшсэн бөгөөд 2001 оны эхээр Монголд “Унгар улсад төгсөгчдийн холбоо”-г байгуулсан байна. Одоо Будапештийн Өтвөш Лорандын нэрэмжит Шинжлэх ухааны их сургуульд монгол багш ажиллаж байгаа ба 1995-1998 оны хавар хүртэл Улаанбаатар хотын Монгол Улсын Их сургуульд унгар багш ажиллаж байлаа. Түүнчлэн дээр дурьдсан ажлын төлөвлөгөө нь Унгар улсад дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтэнгүүдийг (жил бүр 3-4 хүн) Унгар улсад мэргэжил дээшлүүлэх боломжийг олгож байна.

Олон улсын монгол судлалын 5 жил тутамд болдог бага хуралд нилээд тооны Унгарын монгол судлаач оролцдог бөгөөд олон улсын хэмжээнд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, монгол судлаач профессор Кара Дөөрд 1999 оны 5 дугаар сард Монгол Улсын төрийн дээд шагнал хүртэв. Гурван жилийн ажлын төлөвлөгөөний дагуу шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн хооронд идэвхтэй хамтын ажиллагаа өрнөж байгаа билээ. Тухайлбал дорно дахины судлаачид, шавьж цуглуулагчид, шувуу судлаачдын дунд гэх мэт.

Өтвөш Лорандын нэрэмжит Шинжлэх ухааны их сургуулийн Өвөр Азийн тэнхимийн оюутнууд Монгол Улсад үндэстэн ястны судалгааны экспедицийг тогтмол явуулж байгаа билээ.

Биеийн тамирыг хөгжүүлэх салбарт тус хоёр улсын завьчдын коёк-кенүүгийн холбооны хооронд шууд холбоо тогтоогдоод байна.

**Монгол Улс, Унгар улсын хооронд байгуулсан томхон гэрээ,
хэлэлцээрүүд болон ажлын төлөвлөгөөнүүд²**

1. Бүгд Найрамдах Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсын хооронд байгуулсан найрамдалт харилцаа болон хамтын ажиллагааны тухай гэрээ (Будапешт хот 1998 оны 1 дүгээр сарын 28)

2. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1994 оны 9 дүгээр сарын 13)

3. Бүгд Найрамдах Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсын хооронд байгуулсан давхар татвар ноогдуулахгүй байх, орлогын албан татвар болон хөрөнгийн татвараас зайлсхийхэд саад болох тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1994 оны 9 дүгээр сарын 13)

4. Бүгд Найрамдах Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсын хооронд байгуулсан иргэний эрх зүй, гэр бүлийн эрх зүй, эрүүгийн эрх зүйн салбарт харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ (Будапешт хот 1968 оны 11 дүгээр сарын 22)

5. Бүгд Найрамдах Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар улсын Хууль зүйн яамд хоорондын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1992 оны 5 дугаар сарын 25)

6. Бүгд Найрамдах Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсын хооронд байгуулсан Консулийн гэрээ (Будапешт хот 1974 оны 6 дугаар сарын 27)

7. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Мал эмнэлэгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1976 оны 8 дугаар сарын 10)

8. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Соёл, боловсрол шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1996 оны 9 дүгээр сарын 27)

9. Бүгд Найрамдах Монгол Улсын Боловсрол шинжлэх ухаан, соёлын яам болон Бүгд Найрамдах Унгар Улсын Боловсролын яам, Үндэсний соёлын өвийн яам хооронд байгуулсан Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах ажлын төлөвлөгөө (Улаанбаатар хот 2002 оны 11 дүгээр сарын 15)

10. Монгол Улсын Геологийн алба, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар болон Унгар улсын Геологийн алба хооронд байгуулсан Газрын хэвлэл судлалын ухаан ба техникийн хамтын ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр (Будапешт хот 1999 оны 5 дугаар сарын 20)

11. Унгар улсын Өтвөш Лорандын нэрэмжит Геофизикийн институт болон Монгол Улсын Геологийн алба хоорондын хамтын ажиллагааны тухай санамж бичиг (Будапешт хот 1999 оны 5 дугаар

сарын 21)

12. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Монгол-Унгарын Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны комисс байгуулах, түүний ажиллах журмын тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1994 оны 9 дүгээр сарын 13)

13. Бүгд Найрамдах Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Бүгд Найрамдах Унгар Улсын Газар тариалангийн яам хооронд байгуулсан Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн салбарт эдийн засаг, техник-шинжлэх ухааны чиглэлээр хамтран ажиллах тухай хэлэлцээр (Будапешт хот 1995 оны 9 дүгээр сарын 22)

14. Унгар улсын Капошваар хот болон Монгол Улсын Дархан хот хооронд байгуулсан ах дүү хотуудын гэрээ (1973 онд гарын үсэг зурсан энэ гэрээг 1997 онд Капошваар хотод засаг дарга Сита Карой болон Дамбын Хаянхярваа нар шинэчлэн байгуулжээ)

15. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Ургамал хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр (Будапешт хот 1998 оны 1 дүгээр сарын 28)

16. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Дипломат болон албаны гадаад паспорттой иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр (Будапешт хот 1992 оны 9 дүгээр сарын 22)

17. Бүгд Найрамдах Монгол Улсын Дэд бүтцийн яам болон Бүгд Найрамдах Унгар Улсын Зам, холбоо харилцаа, усны аж ахуйн яам хооронд байгуулсан Зам, холбоо харилцааны салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай меморандум (Будапешт хот 1995 оны 9 дүгээр сарын 22)

18. Бүгд Найрамдах Монгол Улсын Дэд бүтцийн яам болон Бүгд Найрамдах Унгар Улсын Зам, холбоо харилцаа, усны аж ахуйн яам хооронд байгуулсан Шуудан, холбооны салбарт хамтран ажиллах тухай гэрээ (Будапешт 1996 оны 6 дугаар сарын 13)

19. Монгол Улсын Шуудангийн алба болон Унгар улсын Шуудангийн алба хооронд байгуулсан Шуудан тээврийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр (Улаанбаатар хот 1999 оны 6 дугаар сарын 11)

20. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Гаалийн салбарт хамтран ажиллах, харилцан туслалцах тухай хэлэлцээр (1995он)

21. Монгол Улсын Худалдаа хөгжлийн банк болон Унгар улсын Гадаад худалдааны банк хооронд байгуулсан Хамтын ажиллагааны хэлэлцээр (1998 оны 1 дүгээр сарын 29)

22. Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим Унгар улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээр (Будапешт хот 1955 оны 9 дүгээр сарын 22)

23. Монгол Улсын Бизнес хөгжүүлэх агентлаг болон Унгар улсын Усны аж ахуйн судалгааны институт хооронд байгуулсан Хамтын ажиллагааны хэлэлцээр (Будапешт хот 1996 оны 6 дугаар сарын 6)

24. Монголын Шинжлэх ухааны академи болон Унгарын Шинжлэх ухааны академи хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээр (Будапешт 1995 оны 5 дугаар сарын 10)

25. Монголын Шинжлэх ухааны академи болон Унгарын Шинжлэх ухааны академи хооронд байгуулсан 2004-2006 онд хамтран ажиллах тухай Ажлын төлөвлөгөө (Будапешт-Улаанбаатар 2004 оны 5 дугаар сарын 27)

26. Монгол Улсын Засгийн газар болон Унгар улсын Засгийн газар хооронд байгуулсан Агаарын тээврийн тухай гэрээ (Улаанбаатар хот 1994 оны 9 дүгээр сарын 13)

27. Улаанбаатар хот болон Будапешт хот хоорондын хамтын ажиллагааны тухай Мэдэгдэл (Будапешт хот 2003 оны 6 дугаар сарын 11, Будапешт хотын Засаг дарга Демски Габор болон Улаанбаатар хотын Засаг дарга М.Энхболд нар гарын үсэг зуржээ)

28. Монгол Улсын Засгийн газрын Гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг Унгар улсын Засгийн газрын Хөрөнгө оруулалт, худалдаа хөгжлийн агентлаг хооронд байгуулсан Харилцан ойлголцох меморандум (Будапешт хот 2004 оны 1 дүгээр сарын 29)

Өндөр хэмжээний айлчлалууд³

1992 онд	Хууль зүйн сайд Балшай Иштван
1994 онд	Ерөнхийлөгч Гөөнц Арпад
1994 онд	Хууль зүйн сайд Н.Лувсанжав
1994 онд	Ерөнхийлөгч П.Очирбат
1995 онд	Монгол Улсын Дээд шүүхийн дарга Д.Дэмбэрэлцэрэн
1995 онд	Унгар улсын Улсын дээд шүүхийн дарга, доктор Шолт Паал
1995 онд	Улсын Их Хурлын дарга Ж.Гомбожав
1995 онд	Унгар улсын Хууль зүйн сайд, доктор Ваштаг Паал
1997 онд	Улсын Хурлын дэд дарга Короди Мариа
1998 онд	Ерөнхий сайд М.Энхсайхан
1998 онд	ХАА, үйлдвэрийн сайд Л.Нямсамбуу (Ерөнхий сайдыг дагалдан)
1998 онд	Хууль зүйн сайд Л.Цог (Ерөнхий сайдыг дагалдан)
1998 онд	Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Совд
1998 онд	Улсын Их Хурлын дарга Р.Гончигдорж

- 1999 онд Газар тариалан хөдөөгийн хөгжлийн сайд доктор Тордьяан Южеф
- 2001 онд Улсын Хурлын дэд дарга Сили Каталин
- 2003 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Ш.Батбаяр
- 2004 онд Худалдаа үйлдвэрлэлийн сайд Ч.Ганзориг нар тус тус айлчилсан байна.

Бусад айлчлал, арга хэмжээнүүд

- 1991 он Капошвар хотын Засаг дарга Дархан хотод айлчлав.
- 1995 он Монгол Улсын Гаалийн байгууллагын төлөөлөгчид Унгар улсад айлчлав.
- 1995 он Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга Ч.Амарболд Будапешт хотын Цагдаагийн газрын дарга, доктор, хурандаа Бодрачка Яношийн урилгаар айлчлав.
- 1996 он Унгар улсын усны мэргэжилтэнгүүдийн төлөөлөгчид судалгааны ажлаар Монгол Улсад айлчлав.
- 1996 он Шуудан, холбооны салбарт хамтран ажиллах гэрээ боловсруулах мэргэжилтэнгүүд Будапештэд яриа хэлэлцээ хийв.
- 1996 он Монгол Улсын авто замын мэргэжилтэнгүүд Унгар улсад судалгааны аялал хийв.
- 1996 он Унгар улсын Зам, холбоо харилцаа, усны яамны Хөлөг онгоцны бие даасан газрын ажилтнууд Монголд далайн тээврийн агентлаг байгуулахтай холбогдуулан далайн хөлөг онгоцоор тээвэр хийх туршлагаа хуваалцахаар Монголд 10 өдрийн айлчлал хийв.
- 1996 он Улаанбаатар хотод зохион байгуулсан Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх талаар болсон бага хуралд Унгар улсын төлөөлөгчид оролцов.
- 1996 он Унгар улсын ЭКСИМ Банкны ерөнхийлөгч Улаанбаатар хотод айлчлав.
- 1996 он Унгар улсын Цагдаагийн ерөнхий газрын Нохой сургах сургуульд Монголын цагдаагийн хоёр офицер суралцав.
- 1996 он Сэлэнгэ аймгийн ХАА-н мэргэжилтэнгүүдэд зориулан Унгар улсын Гөдөллү хотын Газар тариалангийн шинжлэх ухааны их сургууль, Дам суурингийн Ан зохион байгуулах ХХКомпанитай хамтран менежер сургах дамжаа зохион байгуулав.
- 1997 он Унгар улсын Гааль санхүүгийн хяналтын ерөнхий

- 1997 он газрын дарга Арнольд Михай Монгол Улсад айлчлав. Монгол-Унгарын Эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын хуралдаанд төрийн нарийн бичгийн орлогч дарга Гильяан Дөөрдийн тэргүүлсэн төлөөлөгчид оролцов.
- 1997 он Унгар улсын Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн орлогч дарга Кадар Ласло Улаанбаатар хотод зөвлөлдөв.
- 1997 он Монгол Елсын ХАА, үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Зариханы тэргүүлсэн усны аж ахуйн төлөөлөгчид Унгар улсад айлчлав.
- 1997 он Монгол банкны дэд ерөнхийлөгч М.Болдын тэргүүлсэн Монголын банкны мэргэжилтэнгүүд болон төлөөлөгчдөд зориулан Унгарын үндэсний банк болон Бизнесменүүдийн холбоо хамтран сургалтын аялал зохион байгуулжээ.
- 1997 он Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар хариу айлчлал хийв.
- 1997 он Дархан хотын Засаг дарга Капошваар хотод айлчлав.
- 1997 он Сэлэнгэ аймгийн ХАА-н мэргэжилтэнгүүдэд зориулан Унгар улсын Гөдөллү хотын Газар тариалангийн шинжлэх ухааны их сургууль, Дам суурингийн Ан зохион байгуулах ХХКомпанитай хамтран менежер сургах дамжаа зохион байгуулав.
- 1998 он Профессор Кара Дөөрдийн тэргүүлсэн монгол судлаачид Улаанбаатар хотод зохион байгуулсан Монгол судлалын VII бага хуралд оролцсон ба профессор Кара Дөөрдийг Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнажээ.
- 1998 он Унгар улсын газрын тосны ТЕСКО компанийн ерөнхий захирал Лендел Иштван Улаанбаатар хотод зохион байгуулсан хөрөнгө оруулалтын бага хуралд оролцов.
- 1998 он Монгол Улсын Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Д.Очиржав тус хоёр улсын Эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын Монголын хэсгийн даргын хувьд Эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын хуралдаанд оролцов. Гадаад харилцааны асуудлаар зөвлөлдөв.
- 1998 он Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга Будапешт хотын Цагдаагийн газрын дарга, доктор Берта

- Аттилагийн урилгаар Унгар улсад айлчлав.
- 1998 он Унгар улсын 2 мэргэжилтэн Дархан хотод Монгол Улсын хөрс судлал, агро-химийн лабораторын тоног төхөөрөмжүүдийг Унгар улсын Газар тариалан хөдөөгийн хөгжлийн яамны зардлаар шинэчлэв.
- 1999 он Унгар улсын Мезүтүүри суурингийн төлөөлөгчид өөрийн ах дүү хот Эрдэнэ сумд айлчлав.
- 1999 он “Хурд” хамтлаг Унгар улсад аялан тоглолт хийв.
- 1999 он Унгар улсын Геологийн албаны захирал доктор Фаркаш Иштваны урилгаар Монголын Геологийн албаны дарга О.Чулуун Унгар улсад айлчлал хийв.
- 2000 он Дархан хотын Засаг дарга Капошваар хотод айлчлав.
- 2001 он Доктор Кекеши Золтан Ерөнхий нотариатчингийн тэргүүлсэн ах дүү Капошваар хотын төлөөлөгчид Дархан хотод айлчлав.
- 2001 он Будапешт хотноо зохион байгуулсан ИНТЕРПОЛ-ын 70 дугаар бага хуралд оролцсон Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга Л.Батбаярыг Унгар улсын Цагдаагийн ерөнхий газрын дарга, доктор Орбан Петр хүлээн авч уулзав.
- 2002 он Улаанбаатар хотын Багшийн их сургууль дээр Унгар улсын дорно дахин судлаач нэрт эрдэмтэн Лигети Лаошийн дурсгалд зориулсан бага хурал, үзэсгэлэн зохион байгуулжээ.
- 2002 он Унгар улсын Гадаад хэргийн яамны Нутаг дэвсгэрийн 5 дугаар газрын дарга Кери Дөөрд, Консулын газрын дарга Мартин Дөөрд нар Улаанбаатар хотод зөвлөлдөв.
- 2002 он Дархан хотын “МАХЭКСПО” мах комбинатын ерөнхий захирал Капошваар хотод айлчлав.
- 2002 он Гал түймэртэй тэмцэх газрын дарга Д.Хишигбаатар Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, доктор, хошууч генерал Баконди Дөөрдийн урилгаар Унгар улсад айлчлав.
- 2002 он Гал түймэртэй тэмцэх газрын 4 ажилтан Унгар улсад сургалтын аялал хийв.
- 2002 он Унгар улсын Боловсролын яамны төрийн нарийн бичгийн орлогч дарга, доктор Меддеш Петр Монгол Улсад айлчлав.
- 2003 он Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын дарга Унгар улсад айлчлав.

2003 он	Унгар улсын Улсын Хурлын Унгар-Монголын Парламентын бүлгэмийн дарга Чонтош Янош Улаанбаатар хотод зохион байгуулсан Шинээр ардчилал тогтоосон улс орнуудын бага хуралд оролцов.
2003 он	Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газрын дарга П.Сүндэв Унгар улсад айлчлав.
2003 он	Унгар улсын Хил хамгаалах ерөнхий газрын Гадаад харилцааны газрын дэд дарга, хилийн инженер, дэд хурандаа, доктор Вайта Иштваны тэргүүлсэн төлөөлөгчид Монгол Улсад сургалтын аялал хийв.
2003 он	Монгол Улсын ГХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Р.Алтангэрэл Унгар улсын ГХЯ-ны төрийн нарийн бичгийн орлогч дарга Сентиваны Габорттай зөвлөлдөв.
2004 он	Монголын Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга, Ж.Чойжанцан Унгар улсад айлчлав.
2004 он	“Харанга” хамтлаг Унгар улсад аялан тоглолт хийв.
2004 он	Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга А.Баатарцогт Будапешт хотод зохион байгуулсан хил хамгаалах олон улсын бага хуралд оролцов.
2004 он	Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын дэд даргын тэргүүлсэн 3 гишүүн бүхий төлөөлөгчид мансууруулах бодистой хийх тэмцлийн туршлага солилцохоор Унгар улсад тус тус айлчилжээ.

Эх сурвалжууд

1. http://www.mfa.gov.hu/Kulugyminiszterium/HU/Vilag_orszagai/Azsia/mongolia/politika.htm
2. http://www.mfa.gov.hu/Kulugyminiszterium/HUA/Vilag_orszagai/Azsia/mongolia/ketoldaluegyezmeny.htm
3. http://www.mfa.gov.hu/Kulugyminiszterium/HUA/Vilag_orszagai/Azsia/mongolia/felsolatogatasok.htm